

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХИ ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 05 дугаар  
сарын 30-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Оюундарь**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн О.Батнасан, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар нараас 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулахгүйгээр заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг дангаар хэрэглэж болохгүй гэж хуульчилсан байгааг гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүнд оногдуулах хорих ялыг гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр тэнсэх, хойшлуулах зохицуулалтыг оруулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүд холбогдох байгууллагын мэргэжлийн хүмүүсээс асуулт асууж, хариулт авсан бөгөөд Байнгын хорооноос хэлэлцүүлэгт бэлтгэх, холбогдох санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй гэж үзсэн болно.


Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх талаархи Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Ш.РАДНААСЭД**